

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7
2.8.2 Авлага.....	9
2.8.4 Урьдчилгаа	9
2.8.6 БАРАА МАТЕРИАЛ.....	10
2.9.5 НӨӨЦИЙН БАРАА	11
2.8.7 Үндсэн хөрөнгө	11
2.8.9 Өр төлбөр	12
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	13
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	14
2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	15
2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ.....	16
2.11. Шилэн дансны мэдээлэл	16
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	16
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	16
3. Менежментийн захидал	17
3.1 ХАРЬЯА ГАЗРУУДАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.....	17
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	18
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	19
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	20
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
СС	Сангийн сайд
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
СХЗГ	Стандарт, хэмжилзүйн газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
ОБХ	Онцгой байдлын хэлтэс

1. Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.04.24 № 1436
танай _____-ны № _____-т
Аудитын гэрчилгээ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
Ө.ЭНХТҮВШИН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, НББОУС, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig_Kherreg\Yawsan_Bichig\2020\0430SAG32.Docx

001030726

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

A red rectangular official stamp is placed over a handwritten signature in black ink. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style.

Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн харьяа байгууллагуудын бүртгэл тайлагналыг сайжруулж, алдаа зөрчлийг арилгах, санхүүгийн бодлогоор хангаж ажиллах, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 05-наас 2020 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор А.Даваадорж нар гүйцэтгэв.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн ЗГ-2/268 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Монгол Улсын нутаг дэвсгэрт хүн, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг гамшгаас хамгаалах, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх эрхзүйн таатай орчныг бий болгох, хууль тогтоомж, стандарт хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, үндэсний үйлдвэрлэл хөгжүүлэхэд стандарт, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогыг хэрэгжүүлэх, экспорт, импорт, эдийн засгийн өсөлтийг дэмжих” нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шуурхай зохион байгуулах;
- Стандарт, хэмжил зүйн асуудлыг хэрэгжүүлэх;
- Шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах;
- Салбарын мэргэжлийн хяналтын асуудлыг зохион байгуулах;
- Эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх зэрэг болно.

Төсвийн ерөнхийлөн захирагч УСНББОУС, түүнд нийцүүлэн дараах хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Хэмжил зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Шадар сайдын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь нэгдсэн дотоод аудитын нэгж байдаггүй, харьяа төсвийн төвлөрүүлэн захирагч нар нь тус бүрдээ дотоод аудитын нэгжтэй байна.

- Стандарт, хэмжил зүйн газрын Хууль зүй, мониторингийн хэлтэс 2019 онд 9 нэгжид хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөсөн боловч 5 нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зөрчил илрээгүй байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Дотоод хяналт, аюулгүй байдлын газар 2019 онд төв, орон нутгийн онцгой байдлын харьяа 8 байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гарган, зөвлөмж өгч, 5 байгууллагын өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг шалгаж, Шадар сайдын ажлын албанд 2019 оны 2/218 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хууль зүй, мониторингийн хэлтэс 2019 онд төв болон орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж үр дүнг 2019 оны 01/360 тоот албан бичгээр ирүүлсэн. Хяналт, шалгалтаар 2 аймагт 8.9 сая төгрөгийн зөрчил илэрч 5.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авчээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монгол Улсын Шадар сайдын эрхлэх хүрээний байгууллагуудын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэх 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 эрсдэлийг их, 5 эрсдэлийг дунд гэж үнэлэн нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн 211,613.7 сая төгрөгийн 2 хувь буюу 4,232.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн 177,699.5 сая төгрөгийн 2 хувь буюу 3,554.0 сая төгрөгөөр тогтоолоо.

2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,770.1 сая, эцсийн үлдэгдэл 813.4 сая төгрөг болж, 1,956.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Касст байгаа бэлэн мөнгө	9.2	0.5	-8.7
Банканд байгаа бэлэн мөнгө	2,760.9	812.9	-1,948.0
Замд яваа мөнгөн хөрөнгө			
Хадгаламж			
Дүн	2,770.1	813.4	-1,956.7
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	2,769.5	811.6	-1,957.9
Төсөл/сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	0.6	1.8	1.2
Дүн	2,770.1	813.4	-1,956.7

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 4.5 сая төгрөг арилжааны банкинд дахь дансанд, 704.7 сая төгрөг барьцаа хөрөнгийн, 103.2 сая төгрөг ахмадын сангийн дансанд, 1.0 сая төгрөг мөнгөн кассын дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга төсвийн зарцуулалтад нэгдүгээр гарын үсэг зурж төсвийг захиран зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д "дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна", 16.4.5-д "агентлагийн дарга тус агентлагийн төсвийн" гэж заасантай нийцээгүй;
- Онцгой байдлын ерөнхий газар тусгай зориулалтын тоног төхөөрөмж, хувцас хэрэгсэл нийлүүлэх, засвар үйлчилгээ үзүүлэх 25 аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан 5,553.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнгээс чанарын баталгааны барьцаа 184.7 сая төгрөгийг суутгаагүй олгосон;
- Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хоол, унаа болон үр дүнгийн урамшуулалтай холбоотой 182.9 сая төгрөгийн зөрчил гарсан; /ОБЕГ-ын харьяа байгууллагууд 160.0 сая, СХЗГ-ын харьяа байгууллагууд 40.9 сая төгрөг/
- Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар тусгай зориулалтын тоног төхөөрөмж худалдан авах 107.8 сая төгрөгийн санхүүжилтийг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгын гадна зам, талбайн тохижилтын ажлын санхүүжилт 15.5 сая төгрөгийг 2016 оноос хойш хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан;
- Ховд аймгийн Онцгой байдлын хэлтэс тайлант онд төрийн сангийн хянаж баталгаажуулсан цалингийн төлбөрийн хүсэлтийг сольж, ажилчдын цалинг 66.9 сая төгрөгөөр дутуу олгосон байна. Дутуу олгосон 66.9 сая төгрөгийг урсгал засварт 54.9 сая, гишүүнчлэлийн төлбөрт 1.2 сая, түлш болон ажилчдын четон худалдан авахад зориулж 10.9 сая төгрөгийг зарцуулсан;
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ыг зөрчин 59.5 сая төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн; /Төв аймгийн ОБХ 38.0 сая, Орхон аймгийн ОБХ 21.5 сая төгрөг/
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 47.7 сая төгрөгийн гүйлгээ хийсэн; /БЗД-ийн ОБХ 29.3 сая, Төв аймгийн СХЗХ 5 сая, Ховд аймгийн СХЗХ 7.4 сая, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори 6.0 сая төгрөг/
- Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийг зөрчин 38.9 сая төгрөгийн хандив авсан; /Баян-Өлгий аймгийн ОБХ 20.1 сая, Ховд аймгийн ОБХ 18.8 сая төгрөг/
- Баянхонгор аймгийн стандарт, хэмжил зүйн газар тайлант онд үндсэн бус үйл ажиллагаанаас орсон 26.9 сая төгрөгийг Стандарт, хэмжил зүйн газраас өгсөн чиглэлийн дагуу хэлтсийн даргад олгосон.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 5,725.6 сая, эцсийн үлдэгдэл 12,311.9 сая төгрөг болж, 6,586.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/ Бууралт-
Ажиллагчидтай холбогдсон авлага	32.3	36.9	4.6
Татаас, санхүүжилтийн авлага	818.0	53.8	-764.2
Бусад авлага	4,792.4	12,132.1	7,339.7
Төлбөртэй үйлчилгээний авлага	82.9	89.1	6.2
Дүн	5,725.6	12,311.9	6,586.3

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Онцгой байдлын ерөнхий газрын авлага 6,951.7 сая, Стандарт, хэмжил зүйн газрын авлага 22.2 сая төгрөгөөр өсөж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын авлага 18.3 сая, Шударга өрсөлдөөн, Хэрэглэгчийн төлөө газрын авлага 0.7 сая, Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны авлага 367.2 сая, Цагааннуур чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны авлага 1.3 сая төгрөгөөр буурснаас Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлага 6,586.3 сая төгрөгөөр өссөн нь дараах асуудлуудаас голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан тариалангийн бүс нутгуудаар ургац алдсанаас газар тариалан эрхэлдэг зарим иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд хаврын тариалалтад зориулж улсын нөөцийн салбаруудаас олгосон үрийн улаан буудайн зээлийг эргүүлэн төлөх бололцоогүй болсноос 7,624.1 сая төгрөгөөр Онцгой байдлын ерөнхий газрын авлагыг нэмэгдүүлсэн.
- Стандарт, хэмжил зүйн газрын нягтлан бодогч оны эцэст данс андуурч хувь хүний орлогын албан татварын 12.6 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн дансанд шилжүүлсэн, дотоод хяналт шалгалтаар үнэт цаас дутагдаж холбогдох мэргэжилтнүүдээр буцаан төлүүлэхээр 5.2 сая төгрөгийн авлага үүсгэн бүртгэсэн.

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны авлага 367.1 сая төгрөгөөр буурсан нь тус бүсэд хөрөнгө оруулалтын болон газар эзэмших гэрээтэй байсан 30 аж ахуй нэгжийн газрын төлбөрийг анхан шатны шүүхийн шийдвэрийг үндэслэн холбогдох байгууллагуудад хандан шийдвэр гаргуулсны дагуу авлагыг барагдуулсан.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийг зохистой удирдаж чадаагүйгээс тайлант онд авлага үүсгэсэн, тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй 130.0 сая төгрөгийн зөрчил гаргасан; /ОБЕГ-ын харьяа байгууллагуудын 61.0 сая, МХЕГ-ын харьяа байгууллагуудын 39.2 сая, СХЗГ-ын харьяа байгууллагуудын 29.8 сая төгрөг/
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу цаг хугацаанд нь авлагын тооцоо үүсгэж бүртгээгүй 140.8 сая төгрөгийн зөрчил гаргасан. / ОБЕГ-ын харьяа байгууллагуудын 44.2 сая, СХЗГ-ын харьяа байгууллагуудын 96.6 сая төгрөг/

2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 375.1 сая, эцсийн үлдэгдэл 242.9 сая төгрөг болж, 132.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	369.5	231.7	-137.8
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	5.4	11.0	5.6
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			
Цалингийн урьдчилгаа	0.2	0.2	0.0
Томилолтын урьдчилгаа			
Дүн	375.1	242.9	-132.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	375.1	242.9	-132.2
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ			
Дүн	375.1	242.9	-132.2

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Онцгой байдлын ерөнхий газар 230.0 сая, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 11.2 сая, Цагааннуур чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба 1.7 сая төгрөгийн урьдчилгаа дансны үлдэгдэлтэй байна.

2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 30,119.9 сая, эцсийн үлдэгдэл 56,745.7 сая төгрөг болж, 26,625.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	9,968.9	35,038.4	25,069.5
Эм боох материал	390.2	431.8	41.6
Дуусаагүй үйлдвэрлэл	364.9	1,284.7	919.8
Бэлэн бүтээгдэхүүн	524.6	1,433.5	908.9
Хангамжийн материал	18,832.8	18,449.6	-383.2
Биологийн хөрөнгө		65.0	65.0
Мал амьтан	38.5	42.7	4.2
Дүн	30,119.9	56,745.7	26,625.8
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	29,717.2	56,306.2	26,589.0
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	402.7	439.5	36.8
Дүн	30,119.9	56,745.7	26,625.8

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн хөрөнгөөр 27,143.7 сая, гадаад дотоодын иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас хандиваар 3,065.8 сая, байгууллага хоорондын болон бусад тооцоогоор 40,127.2 сая, нийт 70,336.7 сая төгрөгийн бараа материалын орлого авч, байгууллагын үйл ажиллагаа, хангалт, байгууллага хоорондын тооцоо, акт устгалаар нийт 42,089.6 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Босго үнээс давсан бараа ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр 166.9 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн; /Говь-Алтай аймгийн ОБХ 17.8 сая, Дорнод аймгийн ОБХ 149.1 сая төгрөг/
- Шатахууны анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарцуулалтын тооцоог нормоор бодож баримтжуулаагүй, шатахууны урамшууллыг бүртгэж тайлагнаагүй нийт 53.3 сая

төгрөг байна; /Дундговь аймгийн ОБХ 18.8 сая, Дорнод аймгийн ОБХ 10.3 сая, Завхан аймгийн ОБХ 7.7 сая, Говь-Алтай аймгийн ОБХ 1.8 сая, Сүхбаатар дүүргийн ОБХ 8,3 сая, Үндэсний аврах бригад 6.4 сая төгрөг/

- Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын хэлтэс төсвийн зарцуулагдаагүй үлдээдлээс 28.6 сая төгрөгийн хэрэглээний нүүрс нөөцөлсөн;
- Дундговь аймгийн Онцгой байдлын хэлтэс батлагдсан жишиг хэмжээг мөрдөөгүй 13.4 сая төгрөгийн хүнсний материалыг хяналтгүй зарцуулсан;
- Дорнод аймгийн стандарт, хэмжил зүйн газар анхан шатны баримт дутуу 31.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

2.9.5 Нөөцийн БАРАА

Нөөцийн барааны эхний үлдэгдэл 72,540.8 сая, эцсийн үлдэгдэл 74,168.3 сая төгрөг болж, 1,620.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Нөөцийн барааны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барааны нөөц	33,031.0	34,206.5	1,175.5
Үрийн нөөц	6,201.6	3,576.7	-2,624.9
Тэжээлийн нөөц	10,905.8	11,038.2	132.4
Шатахууны нөөц	19,932.7	23,953.7	4,021.0
Буудайн нөөц	81.0	54.3	-26.7
Бусад нөөц	2,394,9.7	1,338.9	-1,056.0
Дүн	72,540.8	74,168.3	1,620.3

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 232,218.7 сая, эцсийн үлдэгдэл 265,287.9 сая төгрөг болж 33,069.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	142,421.6	139,380.1	-3,041.5
Авто-тээврийн хэрэгсэл	30,077.7	33,043.1	2,965.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	16,600.7	12,890.2	-3,710.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,338.4	2,540.5	202.1
Зам, гүүрийн байгууламж	212.6	78.7	-133.9
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	174.3	117.6	-56.7
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3.4	3.4	0.0
Бусад үндсэн хөрөнгө	2,420.5	33,152.8	30,732.3
Дуусаагүй барилга, байгууламж	3,163.7	5,458.3	2,294.6
Ном	16.3	16.3	0.0
Биет хөрөнгийн дүн	197,429.2	226,681.0	29,251.8
Програм хангамж	276.4	464.6	188.2
Бусад биет бус хөрөнгө	34,513.1	38,142.3	3,629.2
Биет бус хөрөнгийн дүн	34,789.5	38,606.9	3,817.4
Үндсэн хөрөнгийн дүн	232,218.7	265,287.9	33,069.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	227,736.0	260,515.3	32,779.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,482.7	4,772.6	289.9
Дүн	232,218.7	265,287.9	33,069.2

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 4,049.1 сая, гадаад дотоодын иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хандив, тусламжаар 2,741.4 сая, хөрөнгө оруулалтаар баригдаж дууссан барилга болон бусад байдлаар 50,190.2 сая, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээр 3,441.7 сая, нийт 60,422.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Засгийн газрын тогтоол, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тушаалын дагуу бүтцийн өөрчлөлт болон байгууллага хоорондын тооцоогоор 6,225.9 сая төгрөгийн хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акталж, данснаас хассан ба тайлант онд 23,674.4 сая төгрөгөөр элэгдлийн зардал тооцоолсон байна.

Нийт үндсэн хөрөнгийн 85.4 хувийг биет хөрөнгө, 14.6 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- *Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/15 дугаар тушаалаар нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах аврах 14 дүгээр ангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй гал унтраах тусгай зориулалтын автомашин, үүргийн гал унтраагуур, үлээгч аппарат зэрэг 4 нэр төрлийн 572.6 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг 2016 онд актаар шилжүүлэн өгч Дотоод хэргийн их сургуульд ашиглагдаж байна;*
- *Төв аймгийн Онцгой байдлын хэлтсийн шуурхай удирдлагын автомашин худалдан авахад дэмжлэг үзүүлэх тендер шалгаруулалтыг аймгийн Орон нутгийн өмчийн газар цахимаар 40.0 сая төгрөгийн өртөгтэйгөөр зохион байгуулахад оролцогч ирээгүй тул шууд гэрээ байгуулах эрхийг захиалагчид олгосноор иргэнтэй 76.3 сая төгрөгөөр автомашин нийлүүлэх гэрээ байгуулсан;*
- *Хан-Уул дүүргийн онцгой байдлын хэлтэс жилийн эцсийн илтгэх хуудасны дүнг санхүүгийн байдлын тайланд тусгасан үндсэн хөрөнгийн үлдэгдлээс 38.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн;*
- *Биетээр байхгүй 30.8 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнасан; /Багахангай дүүргийн ОБХ 2.1 сая, Нийслэлийн онцгой байдлын газар 27.8 сая, Дархан-Уул аймгийн мэргэжлийн хяналтын газар 0.9 сая төгрөг/*
- *Худалдан авсан болон ОБЕГ-аас хуваарилсан Ланд-200 автомашиныг ТӨБЗГ-ын зөвшөөрөл ирээгүй гэсэн шалтгаанаар орлогод аваагүй; /Баян-Өлгий аймгийн ОБХ, Говь-Алтай аймгийн ОБХ/*
- *Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсийн үндсэн хөрөнгийн дансанд газрыг давхардуулан бүртгэсэн;*
- *Аврагч биеийн тамир, техник-спортын хороо босго үнээс давсан бараа ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр 13.1 сая төгрөгийн тавилгын шууд худалдан авалт хийсэн;*
- *Говь-Алтай аймгийн стандарт, хэмжил зүйн газар элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 45 төрлийн 50.1 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй;*
- *Стандарт, хэмжил зүйн газрын төв байрны газар эзэмших гэрчилгээний хугацаа 2016 онд дууссан, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 2009 оноос хойш нэмэлт өөрчлөлт оруулаагүй;*
- *Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй, хорогдлоороо өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй программ хангамжийг данснаас хасаагүй; /Баянхонгор аймгийн ОБХ, Дорнод аймгийн ОБХ, Баян-Өлгий аймгийн ОБХ/*
- *Стандарт, хэмжил зүйн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа байгууллагуудад ашиглаж байгаа санхүүгийн программ хангамж нь "нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ыг хангаагүй.*

2.8.9 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 8,519.0 сая, эцсийн үлдэгдэл 1,524.3 сая төгрөг болж 6,994.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	6,337.1	1,524.3	-4,812.8
Ажилчидтай холбогдсон өглөг	6.8	35.5	28.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	4.9	66.6	61.7
Бусад өглөг	5,952.5	1,289.9	-4,662.6
Урьдчилж орсон орлого	372.9	132.3	-240.6
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>	2,181.9	0.00	-2,181.9
Урт хугацаат зээл	2,181.9	0.00	-2,181.9
Нийт дүн	8,519.0	1,524.3	-6,994.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	8,445.7	1,424.6	-7,021.1
Төсөл, сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	73.3	99.7	26.4
ДҮН	8,519.0	1,524.3	-6,994.7

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст Онцгой байдлын ерөнхий газар 1,072.7 сая, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 331.3 сая, Стандарт, хэмжил зүйн газар 32.6 сая, Шударга өрсөлдөөн, Хэрэглэгчийн төлөө газар 14.2 сая, Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба 72.4 сая, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба 1.1 сая, нийт 1,524.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нийт өр төлбөр 6,994.7 сая төгрөгөөр буурахад Онцгой байдлын ерөнхий газрын 2018-2019 онд цэргийн тэтгэвэрт гарсан албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмжийн 4,984.4 сая төгрөгийн өглөгийг барагдуулсан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Мөн Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай 2016 оны 01 дүгээр сарын 8-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрийн дагуу Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах” төслийн нэгжийн санхүүгийн тайланг Сангийн сайдын тайланд нэгтгэн шилжүүлсэнтэй холбоотойгоор 2,181.9 сая төгрөгийн урт хугацаат төслийн зээлийн үлдэгдлийг хаасан нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийг зохистой удирдаж чадаагүйгээс тайлант онд өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй 50.0 сая төгрөгийн зөрчил гаргасан. /Говь-Алтай аймгийн ОБХ 0.2 сая, Баян-Өлгий аймгийн ОБХ 0.4 сая, Хан-Уул дүүргийн ОБХ 0.6 сая, Үндэсний аврах бригад 15.1 сая, Улсын нөөцийн объект 3 3.2 сая, Говь-Алтай аймгийн СХЗХ 3.9 сая, Сэлэнгэ аймгийн СХЗХ 26.6 сая төгрөг/

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 336,293.7 сая, эцсийн үлдэгдэл 411,443.5 сая төгрөг болж, 75,149.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт -/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	118,092.4	121,463.5	3,371.1
Хуримтлагдсан үр дүн	161,090.7	232,599.9	71,509.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,110.6	57,380.1	269.5
Дүн	336,293.7	411,443.5	75,149.8

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

“Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу 2018 онд газрыг дахин үнэлж, бүртгэхэд гарсан 3,759.4 сая төгрөгийн алдааг залруулснаас шалтгаалан засгийн газрын оруулсан капитал данс өмнөх оноос нэмэгдсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт данс тайлант онд дахин үнэлэгдсэн хөрөнгө акталж устгаснаас 269.45 сая төгрөгөөр нэмэгдэж өөрчлөлт орсон байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Өмнөговь, Увс, Хэнтий, Хөвсгөл, Дорнод, Баянхонгор аймагт шинээр байгуулагдаж байгаа Онцгой байдлын хэлтсүүдийн үйл ажиллагаа эхлээгүйгээс 339, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тэтгэвэрт гарсан, жирэмсэн, амаржсан, хүүхдээ асах чөлөөтэй байгаа ажилтны оронд хүн нэмж аваагүйтэй холбоотойгоор 177, нийт 516 орон тоо дутуу ажилласан байна.

Тайлант онд 7,200.0 сая төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 9,163.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 127 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл/ байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /бусад орлого/	3,600.0	4,747.4	1,147.4	132%
Стандарт, хэмжил зүйн газар /бусад орлого/	3,600.0	4,416.4	816.4	123%
Нийт дүн	7,200.0	9,163.8	1,963.8	127%

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан 147,038.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 132,595.3 сая төгрөгийг урсгал зардалд, 6,363.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 8,079.7 сая төгрөгийг стратегийн нөөц хөрөнгөд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 142,111.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 4,926.7 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 135,951.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 5,065.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 138.8 сая төгрөгөөр давсан нь улсын нөөцөөс олгох барааны борлуулалт нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 141,004.5 сая төгрөг буюу 6,034.1 сая төгрөгөөр дутуу зарцуулж, 95.9 хувьтай байна.

Хөрөнгө оруулалтын 9 төсөл, арга хэмжээнд 6,363.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 6,264.7 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Ажил гүйцэтгэгч байгууллагад гүйцэтгэлээр 5,802.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, 326.7 сая төгрөгийн суутган барьцаа дансанд, 135.4 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлангаар хандив тусламжаар 632.7 сая, ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын

шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөр 6,716.6 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хөтөлбөр арга хэмжээнээс хуваарилсан хөрөнгөөр 16.9 сая, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,620.6 сая, нийт 10,986.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 8,389.1 сая, хөрөнгийн зардалд 836.7 сая, Засгийн газрын урсгал шилжүүлэг 4.7 сая, тэтгэмж, урамшуулалд 1,129.3 сая, нийт 10,359.8 сая төгрөгийг зарцуулж зарцуулаагүй 677.0 сая төгрөгийг оны эцэст татан төвлөрүүлж 40.6 сая төгрөгийг буцаан авахаар авлагаар тусгаж, 636.4 сая төгрөгийг улс, орон нутгийн төсвийн орлогод тооцуулсан байна.

2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 96 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллагад итгэл үзүүлж, 9 санхүүгийн тайланг түүвэрт, 78 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитаар 75 санхүүгийн тайлан “Зөрчилгүй”, 3 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 18,276.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 15,732.8 сая төгрөгийн 62 алдааг залруулж, 107.2 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 1,459.5 сая төгрөгийн зөрчилд 43 албан шаардлага, 976.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 145 зөвлөмж өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Онцгой байдлын ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгч, нийт 1,360.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 742.5 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 605.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 13.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгч, нийт 1,034.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 997.3 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 15.5 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Стандарт, хэмжил зүйн газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгч, нийт 2,691.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,691.4 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 1 алдаа, зөрчилд зөвлөмж өглөө.

Төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн байгууллагуудын 93 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллагад итгэл үзүүлж, 9 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, “Зөрчилгүй” 72, Ховд аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Ховд аймгийн Онцгой байдлын хэлтэс, Үндэсний аврах бригадын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 13,189.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 11,301.6 сая төгрөгийн 53 алдааг залруулж, 91.7 сая төгрөгийн зөрчилд 30 төлбөрийн акт тогтоож, 854.3 сая төгрөгийн зөрчилд 41 албан шаардлага, 942.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 138 зөвлөмж өглөө.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дэлхий нийтэд тархаад байгаа шинэ төрлийн корона вирусийн халдвар (Ковид-19)-аас сэргийлэхэд зориулж Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, олон улсын байгууллага, гадаад улсаас Онцгой байдлын ерөнхий газарт сайн дурын үндсэн дээр бэлэн мөнгө, эд материал хандивлах, үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлж байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны 132 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мэдээллийн дагуу байршуулах хугацаа болоогүй 1 мэдээллийг байршуулаагүй байна.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 335.7 сая төгрөгийн зөрчилд 3.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 3.9 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд, буюу зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Залруулагдаагүй 2,561.0 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 3,554.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул зөрчилгүй дүгнэлтийг өгч байна.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 ХАРЬЯА ГАЗРУУДАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 88 байгууллага, нэгжийн 96 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллагад итгэл үзүүлж, 9 санхүүгийн тайланг түүвэрт, 78 санхүүгийн тайлан аудитад хамрагдсан байна. Аудитаар 75 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 3 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 18,276.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 15,732.8 сая төгрөгийн 62 алдааг залруулж, 107.2 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 1,459.5 сая төгрөгийн зөрчилд 43 албан шаардлага, 976.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 145 зөвлөмж өглөө.

3.1.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх.

Харьяа байгууллагуудын бүртгэл тайлагналыг сайжруулж, алдаа зөрчлийг арилгах, авлага, өр төлбөрийг бууруулах, хариуцлага алдсан албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2-дахь заалтын дагуу холбогдох арга хэмжээ авч үр дүнг дүгнэн, биелэлтийг 2020 оны 09 дугаар сарын 10-ний дотор ирүүлэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	112,594,076.0	147,679,879.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,770,101.3	813,465.3
33	АВЛАГА	5,725,685.8	12,311,979.0
34	УРЬДЧИЛГАА	375,077.5	242,912.4
35	БАРАА МАТЕРИАЛ	30,119,909.1	56,745,743.8
36	НӨӨЦИЙН БАРАА	72,547,062.4	74,168,340.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,056,240.0	3,397,438.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	232,218,720.2	265,287,963.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	232,218,720.2	265,287,963.6
39200	Биет хөрөнгө	197,429,236.0	226,681,102.3
39300	Биет бус хөрөнгө	34,789,484.3	38,606,861.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	344,812,796.2	412,967,843.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,519,095.8	1,524,312.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,337,196.6	1,524,312.1
41300	Өглөг	5,964,211.4	1,392,058.1
41400	Урьдчилж орсон орлого	372,985.2	132,254.1
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,181,899.2	-
42200	Урт хугацаат зээл	2,181,899.2	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	336,293,700.5	411,443,531.1
51	Засгийн газрын хувь оролцоо	336,293,700.5	411,443,531.1
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	118,092,383.2	121,463,495.8
51200	Хуримтлагдсан үр дүн	161,090,695.9	232,599,961.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,110,621.3	57,380,073.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	344,812,796.2	412,967,843.2

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	162,869,723.6	249,370,350.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,552,433.7	97,629,751.8
120	Нийтлэг татварын бус орлого	21,913,275.0	97,629,751.8
122	Тусламжийн орлого	3,639,158.7	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	137,317,289.9	151,740,598.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	170,813,251.3	165,789,338.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	157,707,590.8	165,789,338.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	127,496,538.3	146,483,123.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,896,702.5	82,309,533.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,450,846.5	5,077,921.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,584,985.6	6,014,470.1
2104	Хангамж, бараа материалын зардал	5,735,384.3	6,094,181.8
2105	Нормативт зардал	4,988,642.1	3,966,042.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,416,378.1	2,572,891.9
2107	Томилолт, зочны зардал	2,388,461.9	3,012,814.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,782,638.8	4,822,330.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,252,498.4	32,612,938.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,211,052.5	19,306,215.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,105,660.5	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-7,943,527.7	83,581,011.1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	62,077.5	4,663.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,837,340.1	11,910,132.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-21,718,790.3	71,675,541.7

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	160,322,682.4	167,374,337.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,795,122.4	14,972,550.5
120	Нийтлэг татварын бус орлого	17,155,963.7	14,972,550.5
122	Тусламжийн орлого	3,639,158.7	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	139,527,560.0	152,401,786.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	142,255,062.7	154,385,040.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	142,255,062.7	154,385,040.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	113,542,530.3	129,053,037.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,512,260.5	82,148,041.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,429,918.6	5,065,234.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,791,349.4	6,021,546.4
2104	Хангамж, бараа материалын зардал	4,332,463.7	4,164,366.0
2105	Нормативт зардал	5,055,982.5	5,517,182.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,619,924.8	4,044,871.8
2107	Томилолт, зочны зардал	2,252,776.4	2,560,176.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,591,516.8	6,362,132.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,956,337.6	13,169,486.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,712,532.4	25,332,003.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	18,067,619.7	12,989,296.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,740,163.0	14,945,932.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,740,163.0	14,945,932.5
2200	Дотоод эх үүсвэрээр	16,740,163.0	14,945,932.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-16,740,163.0	-14,945,932.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	60,438.9	0.0
14	Бусад эх үүсвэр	62,012.5	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,573.7	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,387,895.5	-1,956,635.9
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,382,205.7	2,770,101.3
